



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 18 өдөр

Дугаар

0127

Улаанбаатар хот

Гарын үсэг зурах эрх олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Сангийн сайдын 2015 оны 196 тоот тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх" журмын 20.4 дүгээр хэсэг, Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан "Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төсөл"-ийн зээлийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төсөл"-ийн зээлийн гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор зээлийн данс болон тусгай дансны гүйлгээ, санхүүгийн баримтанд 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хоёрдугаар гарын үсэг зурах эрхийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д олгосугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 490 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /С.Төгсдэлгэр /-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080461